

Х.ЧОЙБАЛСАН, Ю.ЦЭДЭНБАЛ, Ж.ЛХАГВАСҮРЭН НАРЫН ДАЙЧИН НӨХӨРЛӨЛ

Ц.Жамбалсүрэн

Товч агуулга: Монгол улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдлын төлөө цогтой тэмцэгчид, XX зууны Монгол цэргийн нэрт зүтгэлтнүүд: Х.Чойбалсан, Ю.Цэдэнбал, Ж.Лхагвасүрэн нарын дайчин нөхөрлөлийн тухай өгүүлжээ.

Түлхүүр үг: Тусгаар тогтнол, Хошой Баатар, Маршал Х.Чойбалсан; Хошой Баатар, Маршал Ю.Цэдэнбал; Улсын Баатар, Армийн генерал Ж.Лхагвасүрэн; харилцаа, хамтын ажиллагаа.

1940 он Монгол орны хувьд нэн чухал утга учиртай он жил байлаа. Энэ түүхэн цоо шинэ үеийн зорилтыг тодорхойлох үүргийг 1940 оны III сарын 20-ноос IV сарын 5 хүртэл хуралдсан МАХН-ын X их хурал гүйцэтгэсэн юм. Их хурал дээр Намын улс төрийн тайланг Х.Чойбалсан тавьж, мал аж ахуйг хөгжүүлэх асуудлаар Ю.Цэдэнбал илтгэл тавьжээ.

Намын X их хурал Ю.Цэдэнбалыг НТХ-ны гишүүнээр сонгож, бүгд хурал 1940 оны IV сарын 8-нд түүнийг Төв Хорооны Ерөнхий нарийн бичгийн даргаар сонгожээ. МАХН-ын Төв Хорооны 1940 оны IV сарын 8-ны өдрийн I бүгд хурлын тогтоолд: "... нөхөр Чойбалсангаас Ерөнхий нарийн бичгийн даргыг сонгоё хэмээсэнд гишүүдээс санал гаргасны ёсоор нөхөр Цэдэнбалыг МАХН-ын Төв Хорооны Ерөнхий нарийн бичгийн даргаар сонгов..."¹ гэжээ. Ю.Цэдэнбалыг хамгийн гол нь Х.Чойбалсан дэмжжээ. Тэрээр хэлэхдээ: "Цэдэнбал бага наснаасаа дотоод, гадаадын сургуульд суралцаж, эрдэм боловсролтой болж, улс орноо хөгжүүлэх үйл хэрэгт бүх хүчээ дайчилж яваа залуу боловсон хүчний нэг юм. Шинээр төрөн гарч байгаа өндөр боловсролтой, оюуны их чадвартай, ажилч хичээнгүй, даруухан, үнэнч шударга ийм шилдэг залуу боловсон хүчнийг зоригтой дэвшүүлж түүнд итгэл үзүүлэх нь зүйтэй"².

¹ МАХН-ын Төв архив.ф. 1, т. 8, х.п. 42, т. 1

² П. Шагдарсүрэн. Миний мэдэх Маршал Чойбалсан. -УБ., 2000. т. 42

“Цэдэнбал ажил хэрэгч, идэвх зүтгэлтэй, боловсрол сайтай. Цэдэнбал бид хоёр Сталинтай уулзсан, тэр үед түүний зан ааш, боловсролын хэмжээг нөхөр Сталин их өндөр үнэлсэн. Түүнээс гадна Цэдэнбал техникумын багш байхаасаа эхлэн НТХ, Засгийн газрын улс төрийн дугуйлангийн багшаар ажиллаж байгаа шүү”³ гэж магтаж байжээ.

Ю.Цэдэнбалыг улс төрийн тавцан дээр шууд дэмжин гаргаж ирснийхээ дараа ч Маршал Х.Чойбалсан түүнд эцэг ёсны анхаарал халамж тавьж, эцэг Юмжаа насан өөд болсон хүнд үед нь ээжтэйгээ уулзахыг зөвлөж нутагт нь явуулж, Баруун аймгуудад ажиллах далимдаа Увс аймгийн Давст суманд Цэдэнбалын ээж Я.Заяагийн дэргэд зочилж, өөрийн бодол санаагаа илэрхийлж үг хэлсэн нь тэмдэглэгдэн үлджээ. Маршал Х.Чойбалсан хэлэхдээ: “Би МАХН-ын Төв Хорооны Ерөнхий нарийн бичгийн даргыг төрүүлсэн гавьяатай эх Заяа Танд баяр хүргэхээр алс хол замыг туулж, танай дөрвөд нутагт ирлээ. Та бол улс эх орондоо үнэхээр хэрэгтэй хүү төрүүлжээ. Эх хүн болгон НТХ-ны Ерөнхий нарийн бичгийн даргыг төрүүлээд байдаг юм биш ээ. МАХН-ын ТХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга бол надаас том хүн шүү. Би танай хүү Цэдэнбалыг нэлээд хэдэн жилийн өмнөөс судлаж байсан. Орос Улсын Эрхүү хотод онц сурч байх үеэс нь таньдаг болсон. Цэдэнбал бол үнэхээр ухаантай, эрдмийг шамдан сурсан шинэ хүчин учраас Сангийн яамны сайдаар тавиад ажил дээр нь бас анхаарч судлав. Цэдэнбал хийсэн ажилдаа нягт нямбай, эзэн болдог онцлогтой. Зав чөлөө бүхнийг ном уншихад зориулж мэдлэгээ ямагт дээшлүүлж байдаг. Зан аашаар тогтуун томоотой. Би намын Х их хурлын өмнө Зөвлөлтөд ажлаар явахдаа Цэдэнбалыг дагуулж явж чухам ямар хүн болохыг дахин туршиж үзсэн. Энэ хугацаанд ер нь сайн хүн болох нь танигдсан учраас би Таны хүү Цэдэнбалыг ийм өндөр албан тушаалд дэвшүүлэн гаргаж тавилаа. Монгол Улсад эрдэм мэдлэгтэй хүн хэрэгтэй. Цэдэнбал бол Монгол Улсаа хөгжүүлэхэд үнэхээр түшиг болж чадах хүн”⁴ гэжээ. Зарим судлаачдын үзэж буйгаар “Чойбалсан нөхөр Цэдэнбалыг нилээд дээр үеэс судласан бөгөөд айхтар олон янзаар нарийн судлаж, өөрийн залгамжлагчид бүрэн тохирох хүн гэдгийг мэдсэний дараа бүр сургуульд байхад нь аминчлан уулзаж, өөрийн алсын бодол санааг ч түүнд ойлгуулжээ.”⁵ Маршал Х.Чойбалсан Ю.Цэдэнбалыг дэмжиж дэвшүүлэхдээ мэргэжил боловсрол, хувийн сайн зан төрхөөс гадна бусад байдлыг ч нарийн тооцжээ. Олон улсын хүрээллийн тухайн цагийн нөхцөлд Оросын их ард түмэнд

³ Бүтээлч үйлсийн тод мөр: Намын ахмадуудын дурсамж.- УБ., 2001, т. 228

⁴ Маршал Чойбалсан Цэдэнбалын эх Заяагийн дэргэд зочилж хэлсэн энэ үгийг тэр үед Увс аймгийн дарга байсан Осор тэмдэглэж АИХ-ын архивт шилжүүлснийг “Хүмүүн толь” 1993, VIII сар, № 1-д нийтэлжээ.

⁵ Толь, 1997, II, № 23, 24

хүндэтгэлтэй ханддаг бодлогоо залгамжлуулахыг тэр хүсч байв. Олон үндэстэн ястны өлгий нутаг – Баруун хязгаараас шинэ хүн дэвшүүлэх нь улс төрийн ач холбогдолтой гэж үзэж байв. Түүнчлэн гучаад онд монгол орныг дайрсан хэлмэгдүүлэлтийн хар шуурганд оролцоогүй цоо шинэ хүн гаргахыг эрмэлзэхдээ Ю.Цэдэнбалын зөөлөн дөлгөөн, ухаалаг төрхийг үнэлсэн төдийгүй удам судрыг нь ч сайтар судалж, эх Заяагийн дүү Цэвэлжин ямар ч гэмгүй атлаа хилс хэргээр буудагдсаны улмаас хүнийг хэлмэгдүүлэн хохироохын гайг Юмжаагийнхан сайтар ухаарсан болохыг, түүнчлэн аливаа ноцтой асуудалд зовлон үзсэн хүмүүс ухаалаг нигүүлсэнгүй сэтгэлээр хандах байх гэсэн итгэл нь Ю.Цэдэнбалыг сонгон дэмжихэд нь мөн л нөлөөлсөн ажээ.

Х.Чойбалсан насан өөд болсон нь. БНМАУ-ын Ерөнхий сайд, шалгарсан Хошой Баатар, Улсын Маршал Х.Чойбалсан дөчөөд оны сүүлээс бие нь чилээрхэх болж 1949 оны VIII сард Москвад очиж шинжилгээ хийлгэж, Сочид очиж сар гаруй сувилуулжээ. Тэр үедээ Сталинтай уулзсан байна. Маршал Чойбалсангийн бие 1951 оны XI сарын сүүлчээс эрс муудаж, гэртээ хэвтэж эмчлүүлэх болжээ. Эхний үед түүний биеийг Эрүүлийг хамгаалах яамны сайд Дугар үзэж байлаа. Сүүлдээ Монголын Засгийн газрын урилгаар Зөвлөлтийн профессор Вишневский тэргүүтэй эмч нарын бүлэг ирж, урьдчилсан шинжилгээ хийж бөөрний хавдартай гэж оношилжээ. Эмч нарын зөвлөснөөр Намын Төв Хорооны Улс төрийн Товчоо Маршалыг Москвад эмчлүүлэх шийдвэр гаргасан байна. Х.Чойбалсангийн референт Д.Шаравын дурссанаар: “Маршал явахынхаа өмнө Ю.Цэдэнбал бид хоёрыг дуудаад өрөөндөө байсан тусгай сейфүүдийн материалыг бүртгэлээр нь бидэнд шилжүүлж, түлхүүрийг Ю.Цэдэнбалд өгсөн юм. Мөн гэртээ байсан бүх юмаа янзлаад түлхүүрээ Гүндэгмаа гуайд үлдээсэн. Одоо бодоход Х.Чойбалсан эргэж ирэхгүйгээ мэдсэн бололтой”⁶ гэжээ.

Х.Чойбалсан 1952 оны I сарын 26-нд Москвагийн цагаар 18 цаг 50 минутад, билэгийн тооллын 16 дугаар жарны хар луу жилийн өвлийн адаг сарын битүүний шөнө Улаанбаатарын цагаар 23 цаг 50 минутад таалал төгсчээ.

Ю.Цэдэнбалыг бага залууд нь дэмжин туслаж, нийгэм, улс төрийн өндөрлөгт гаргаж, 12 жил төр, улсыг удирдах их туршлагаасаа сургаж, бараг л эцэг шиг нь (Х.Чойбалсан Ю.Цэдэнбалаас 20 насаар ах байжээ) түшиж тулж явсан, Монголын нам, шинэ засаг төрийг үндэслэгчдийн нэг насан өөд болсныг хүний хувьд Ю.Цэдэнбал хамгийн их харуусан хүлээж авсан нь аргагүй байлаа.

Төрт ёсоо дээдлэх, ахмад үеэ хүндэтгэх ард түмнийхээ уламжлалд үнэнчээр хүмүүжсэн Ю.Цэдэнбал Х.Чойбалсанд хүндэтгэлийн дээдийг үзүүлж

⁶ Л. Бат-Очир. Чойбалсан: Намтрын нь балархайг арилгахуй.-УБ..1996.. т. 189

сүүлчийн замд нь үдсэн юм. Маршал Х.Чойбалсанг тахин шүтэх, хүндэтгэх явдал ард түмний дунд хүчтэй байсан нөхцөлд ингэхээс ч өөр аргагүй байлаа. “Ю.Цэдэнбал Маршалын шарилыг Лениний шарилын нэгэн адил урт удаан хугацаагаар хэвээр нь байлгаж болох эсэх талаар асуулгасан байв. Шарилыг занданшуулах нь Монголын нөхцөлд төвөг бэрхшээлтэй гэдгийг тэд ойлгож байсан боловч Зөвлөлтийн эмч нарын мэдлэг чадвар, Улаан талбай дахь бунханд хийсэн ажиглалт туршлагад найдаж байв. Анагаах ухааны урдаа барьдаг эрдэмтэд Маршалын эх цогцсыг урт удаан хугацаанд хадгалах техникийн нөхцөл бололцоо Монголд байхгүй гэж үзжээ...”⁷

Энэ үед Ю.Цэдэнбалын удирддаг НТХ-ны УТТ 1952 оны II сарын 6-нд “Чойбалсангийн шарилыг оршуулах тухай” 11/20 тоот тогтоол; “Сүхбаатар, Чойбалсангийн шарилыг үүрд хадгалах бунхныг Засгийн газрын индрийн дотор барих тухай” 11/19; II сарын 13-нд “Чойбалсангийн нэрэмжит газар, цалин, марк гаргах тухай”; “Чойбалсангийн дурсгалыг мөнхжүүлэх тухай” 11/21 тоот тогтоолууд гаргаж, Улаанбаатар, Алтанбулаг, Булган, Чойбалсан аймаг, сумын төвд хөшөө босгох, Чоно голын уурхай, Ардын цэргийн мото механикжсан VI бригад, Нийслэлийн III хороо, пионерийн зуслан, Булган дахь улсын аж ахуйг нэрэмжит болгох, Улаанбаатарт музей байгуулах, дурсгалын самбаруудыг хадах, нэрэмжит цалин бий олгох, хэлсэн үг, илтгэлийн эмхтгэл гаргах, шуудангийн марк гаргах шийдвэр гаргасан юм.”⁸ 1952 оны II сарын 21-нд УТТ “Богд уулын нэрийг өөрчлөн Чойбалсан гэдэг нэртэй болгох тухай” 14/28 тоот; “Чойбалсанг оршуулсан тухай баримтат кино хийх тухай” 12/25 тоот тогтоол гаргажээ.⁹ Мөн оны V сард “Чойбалсангийн мавзолей байгуулах тухай”, “Чойбалсангийн ордон музейн талаар авах зарим арга хэмжээний тухай” УТТ-ны тогтоолууд гарч хэрэгжив.¹⁰ Маршал Х.Чойбалсанг Монголын ард түмэн тэр үед гүн хүндэтгэж байсныг Ю.Цэдэнбал энэ бүхнийг зохион байгуулахдаа харгалзжээ.

Х.Чойбалсан, Ю.Цэдэнбал хоёрын харилцаа. Ю.Цэдэнбал, Х.Чойбалсангийн залгамжлагчийн хувьд түүнд ямагт сайнаар хандаж байсан боловч нэг хүнийг тахин шүтэх явдал, хэлмэгдүүлэлтийн үйл явдалд холбогдож байсны хувьд нь гэвэл харин өмгөөлөн хамгаалж, өргөмжилж чадаагүй юм.

Ю.Цэдэнбал хувьсгалт хууль ёсыг зөрчих, олноор хилсдүүлэх, нэг хүнийг тахин шүтэх явдалтай тууштай тэмцэж, 1956, 1962 оны Намын Төв Хорооны

⁷ Л.Шинкарев. Цэдэнбал, Филатова хоёр: Хайр дурлал, эрх мэдэл, эмгэнэл. –УБ., 2004, т. 91

⁸ МАХН-ын Төв архив. ф. 4, д. 19, х.н. 5, т. 103-117

⁹ МАХН-ын Төв архив. ф. 4, д. 19, х.н. 5, т. 116, 158

¹⁰ МАХН-ын Төв архив. ф. 4, д. 20, х.н. 16, т. 12-13

бүгд хурлууд дээр Х.Чойбалсаныг тахин шүтэж байсан талаар ул үндэстэй хатуухан шүүмжилж байсан боловч түүнийг мушгин муучлах, “ясыг нь өндөлзүүлэхийг” хүсдэггүй байжээ. 1962 онд НХШК-ын дарга байсан Гэндэнтэй ярихдаа: “Та нар Цагаатгалын комиссын ажлын тухай өрөөсгөл илтгэл бичиж, Чойбалсанг цусанд ханадаггүй ямар нэгэн аймшигтай амьтан мэтээр дүрсэлсэн. Чойбалсантай ганц удаа ч болсон уулзаж явсан уу? Та хавар Баян-Өлгийд ярихдаа: Чойбалсан юу ч мэддэггүй хүн байсан, түүнд мэдлэг гэх юм байгаагүй. Гарын үсгээ л арайхийж зурж чаддаг байсан. Бүх юмыг нь бусад хүмүүс бичиж өгдөг байсан гэсэн. Та үүнийг хаанаас олж мэдсэн юм бэ?”¹¹ гэж асууж байснаас үзэхэд аливаад туйлшран нэг бол тахиж шүтдэг, нэг бол газарт ортол нь муулдаг явдлыг дургүйцдэг байсан ажээ.

Тэр үед бичсэн өдрийн тэмдэглэлдээ Ю.Цэдэнбал: “Чойбалсангийн тухай ярихдаа тэр хүн бидэнд өгч чадах байсан бүхнээ өгсөн юм шүү гэдгийг онцлон тэмдэглэх хэрэгтэй. Үүнээс илүү юмыг шаардаж болохгүй л дээ. Жишээ нь: Зарим хүмүүс манай хөгжлийн олон асуудлыг онолын үүднээс нэгтгэн дүгнэсэнгүй гэж түүнийг зэмлэх гэдэг. Тэр хүн үүнийг хийж чадахгүй байсан. Энэ бол түүний хувьд хүнд бэрх ажил, түүний онол, үзэл суртлын бэлтгэл хангалттай биш байсан. Тийм дүгнэлтийг олон хүний хүчээр л хийж болно. Чойбалсан суралцах гэж оролддог байсан. ЗХУКН-ын түүхийг судлаж байсан. Лхагва гараг бүр гэртээ сууж хичээллэдэг байсан. Хичээл нь хүнд байсан байх, нас ахисан болохоор”¹² гэж өрөвдөх сэтгэлээр бичиж байжээ.

Ю.Цэдэнбал 1963 оны үеийн өдрийн тэмдэглэлдээ: “Чойбалсан ер нь Зөвлөлтийн л гэсэн юм бүхэнд хязгааргүй итгэдэг байсан бөгөөд энэ нь ч манай ажилд их чухал байлаа. Боловсон хүчин хүрэлцээгүй байлаа. Дээд боловсролтой хүн хуруу дарам байсан. Чойбалсангийн өөрийнх нь мэдлэг ч хангалттай биш. Тэр ямар нэгэн төслийг Зөвлөлтийн сургагч буюу зөвлөхөөр үзүүлж байж л сая санаа нь амардаг байсан. (Тэднийг большевик намын мэргэн ухаантнууд гэж үздэг байж л дээ). Гэтэл зарим зөвлөх нь мэргэжлээс тун ч хол зөвлөгөө өгөх нь цөөнгүй байлаа. (Ямар нэг шалтгаанаар, ялангуяа нөхцөл байдлыг мэдэхгүйн улмаас). Гэтэл Чойбалсан тэр зөвлөгөөг нь бүр үнэнд тооцдог байлаа. Чойбалсан ЗХУКН, түүний шийдвэр, түүний цэцэн мэргэн ухаан зэрэгт тэгж л хязгааргүй итгэдэг байсан юм даа”¹³ гэжээ. Ю.Цэдэнбалыг нэг хүнийг тахин шүтэх явдлыг хамгааллаа, Х.Чойбалсанг хамгааллаа гэж олон жилийн турш шүүмжилсэн юм. Чухамдаа Зөвлөлтийн ард түмнийг гүнээ хүндэтгэх бодлогыг Ю.Цэдэнбал өмнөх төрийн тэргүүн Х.Чойбалсангаас өвлөн баримталсан бөгөөд энэ байр сууриныхаа үүднээс

¹¹ Гэрэл, сүүдэр: Ю.Цэдэнбалын хувийн тэмдэглэлээс. –УБ., 1992, т.49

¹² Гэрэл, сүүдэр: Ю.Цэдэнбалын хувийн тэмдэглэлээс. –УБ., 1992, т.56

¹³ Гэрэл, сүүдэр: Ю.Цэдэнбалын хувийн тэмдэглэлээс. –УБ., 1992, т.57-58

Х.Чойбалсанг бүх талаар гутаан доромжлохоос түүнийг хаацайлан хамгаалж байсан билээ.

Бүр хожим Москвад байхдаа Маршал Чойбалсангийн талаар ямар сэтгэгдэл, ямар дүгнэлттэй байдаг вэ? гэсэн сурвалжлагчдын асуултад: “Маршал Чойбалсан чинь Сүхбаатарын хамт ардын хувьсгалыг хийлцсэн гарамгай удирдагч байсан. Гэхдээ дээд сургууль төгсөөгүй, цэргийн боловсролтой Маршал хүн дээ. Маршалыг би хүндэтгэдэг байсан. Тэр бол төр барих туршлагатай, их нэр хүндтэй хүн байлаа”¹⁴ гэснээс үзэхэд энэ хоёр хүн жирийн хүний л адил хүмүүс, нэг нэгэндээ хүнлэг ёсоор хандаж, Монгол Улсаа л хөгжүүлэх гэж зүтгэж явсан ажээ.

Нэг хүнийг тахин шүтэхийн хор уршгийг арилгахын төлөө. МАХН-ын ТХ-ны II бүгд хурал (1962.I сар) дээр Ю.Цэдэнбал “ЗХУКН-ын XXII их хурлын дүн ба МАХН-ын зорилт” гэсэн илтгэл тавьж, нэг хүнийг тахин шүтэх явдлын хор уршигтай хийх тэмцэл чухал байгааг заав. “Бид өнгөрсөн үеийн үйл явдлыг болон түүнтэй уялдуулан Чойбалсангийн үйл ажиллагааг үнэлэхдээ түүхэнд нэрээ үлдээсэн хүний нь хувьд сайн, муу бүхий л талыг нь тунгааж гарцаагүй үнэн зөв, жинхэнэ шинжлэх ухааны үндэстэй үнэлэлт өгөх ёстой... Нэг хүнийг тахин шүтэхийн хор уршгийг нам, улс, аж ахуй, соёлын байгуулалтын салбар бүхэнд бүрмөсөн арилгаж, зохих дүгнэлт хийж, хойшид сургамж авах ёстой”¹⁵ гэж Ю.Цэдэнбал үзэж байлаа.

Тэрээр Х.Чойбалсангийн зүтгэл гавьяаг дурдахын хамт “н.Чойбалсан ширүүн зантай, хартай хүн байсан юм. Эдгээр дутагдал нь Чойбалсангийн ажилд аргагүй муу нөлөө үзүүлж, хувьсгалт хууль ёсыг зөрчин, хувьсгалын хэрэгт үнэнч хүмүүсийг ямар ч үндэсгүйгээр дайчлан баривчилж, ноцтой алдаа завхрал гаргахад нь ямар нэгэн хэмжээгээр нөлөөлсөн байж болох юм” гээд “Гэндэн, Дэмид нарын зориуд байгуулсан хувьсгалын эсэргүү хуйвалдааны байгууллага гэгчийн хэрэг тэр аяараа хуурамч, зохиомол зүйл байсан нь одоо нэгэнт тодорхой болов”¹⁶ гэж зоригтой илчилсэн юм.

Х.Чойбалсангийн түүхэн ролийг үнэлэх талаар өөрийн гаргасан алдааг ч Ю.Цэдэнбал шүүмжилжээ. Тэрээр “нөхөр Чойбалсангийн 50 насны ойд зориулсан хурал дээр 1945 оны II сарын 8-нд миний тавьсан илтгэл нэг хүнийг тахин шүтэхэд зарим талаар хувь нэмэр оруулсан бөгөөд Чойбалсангийн гавьяаг дэндүү магтаж, ардын хувьсгал ялсан цагаас хойш БНМАУ-д хувьсгалт гүнзгий өөрчлөлт хийхэд нам ба ард түмний гүйцэтгэсэн үүргийг дутуу үнэлсэн зүйл болсон гэдгийг хэлэх хэрэгтэй”¹⁷ гэжээ. Цэдэнбал судлаач,

¹⁴ Ю.Цэдэнбалын Академийн архив. ф. I, хн. 13, т. 13

¹⁵ Ю.Цэдэнбал. Илтгэл, өгүүлэл, хэлсэн үг, илгээлт. 6. III, -УБ., 1967, т. 98

¹⁶ Мөн тэнд. т. 102

¹⁷ Ю.Цэдэнбал. Илтгэл, өгүүлэл, хэлсэн үг, илгээлт. 6. III, -УБ., 1967, т. 102

доктор (Sc) Ц.Гүрбадам: “Цэдэнбал нь сталинизмын хувьд Мао Цзе дун, Хрущев хоёрын дундач байр суурьтай байсан бололтой”¹⁸ гэж хэлсэн нь үнэнд дөхөж очсон гэж хэлж болно.

Нэг хүнийг тахин шүтэх асуудлаар Ю.Цэдэнбалыг аядуу бодлого баримталж байсан хэмээн шүүмжилж болох талтай ч энэ нь учир шалтгаантай байв. Ю.Цэдэнбалын ээжийн дүү Цэвэлжин ямар ч буруугүй мөртлөө гучаад онд хэлмэгдэн буудагдсан нь тэдний гэр бүлийн амьдралын нэн эмгэнэлт хуудас болжээ. Ю.Цэдэнбалын дүү Ю.Аюуш дурсахдаа: “Бал ах бид Цэвэлжин ахын талаар үе үе дурсан ярьдаг байсан. Энэ гунигт түүх нь хэлмэгдлийн асуудалд хандах ахын бодлого байр суурийг тодорхойлсон гэж би боддог. Энэ асуудал нэг талаар тухайн үеийн нам, төр, засгийн бодлого, нэр хүндтэй холбоотой, хүмүүсийн сэтгэл зүйтэй холбоотой байсан учраас ах улс төржүүлэн шуугиулахаас болгоомжилж байсан. Манай ээж насан өөд болсны дараа бид аав, ээж, нагац ах нарынхаа тухай нэг удаа дурсан ярих үед ах: “Всеми свое время. Гучаад оны хэлмэгдүүллийн асуудалд бид одоо хувийн харамслын үүднээс хөнгөн хандаж болохгүй. Нам, төрдөө хандах, монголчууд, монголчууддаа хандах гомдон өширхөх үзэл их дэлгэрвэл бидэнд, үндэсний эв нэгдэлд таарахгүй. Чи бид хоёр ч гомдол харууслаа хэлэх үе ирэх ч юм бил үү. Харин одоо биш” гэж хэлж байсныг би тод санаж байна”¹⁹ гэж хэлснээс үзэхэд нийгэм, улс төрийн энэ эмзэг асуудалд нэг хэсэгтээ болгоомжтой хандах нь зөв гэж Ю.Цэдэнбал үзэж байжээ.

Нэг хүнийг тахин шүтэх асуудлаар Ю.Цэдэнбалын байр суурьт юу нөлөөлж байсан тухай түүхч, академич Б.Лхамсүрэн тэмдэглэхдээ: “Завхралын хэргийг илчлэн тэмцэх асуудалд Зөвлөлтийн тухайн үеийн зарим удирдагчид хэрхэн хандаж байсны хоёр жишээг дурдъя. 1957 оны V сарын 14-нд МАХН-ын ТХ-ны нэгдүгээр нарийн бичгийн дарга Д.Дамба, УТТ-ны орлогч гишүүн Л.Цэнд нар ЗХУКН-ын ТХ-ны нарийн бичгийн дарга М.Сусловтой уулзаж, 1937-1939 оны үед баривчлагдаж, ЗХУ-д хэргээ таслуулсан Гэндэн, Амар, Догсом, Лувсаншарав нарын 32 хүний хэргийн материалыг Монголын талд шилжүүлэн авах асуудлыг тавихад “Зөвлөлтийн хуулийн зохих байгууллагад даалгавар өгч, олдоод байгаа 26 хүнд манай зүгээс хууль ёсны зэмлэл хүлээлгэх ямарч үндэсгүй гэж хянагдсан учраас бүгдийг цагаатгасан, холбогдох материал та нарт хэрэг байна уу даа, үзэх үзэхгүй хүмүүс материалыг уншиж элдэв яриа гаргах зүйл болох юм биш үү, ийм учраас бид энэ талаар ямар нэгэн материал өгөх хэрэггүй гэж үзэж байна. ...Цагаатгасан материалыг нийтэд зарлах хэрэг байна уу, үгүй юу?

¹⁸ Ю.Цэдэнбалын Академийн архив. ф.1, хн.6, т.390

¹⁹Ю.Цэдэнбал: Хүмүүсийн дурсамж. б.1,-УБ.,2002,т.31

Намд ашигтай юу, хортой юу? Бидэнд гашуун туршлага бий. Харгис хүчин цагаатгасан материалыг хорт ажиллагаандаа шалтаг болгон ашигласан, Польшид намын эсрэг хөдөлгөөн гарсан, Унгарт Райкийг цагаатгасныг шалтаг болгон үймээн гарсан. Дотоод цагаатгал, гадаад цагаатгал хоёр өөр, цагаатгалыг зөвхөн намын дотоодод хийгээд төгсгөл болгож болно” гэж М.Суслов хэлж байжээ. ЗХУКН-ын энэ бодлого, зөвлөлгөөнийг манайд тодорхой хэмжээгээр харгалзан үзэхээс өөр арга бараг л байгаагүй билээ. 1962 оны XI сарын 26-нд ЗХУКН-ын ТХ-ны нарийн бичгийн дарга Ф.Козлов, хэлтсийн орлогч Л.Толкунов нар МАХН-ын ТХ-ны I нарийн бичгийн дарга Ю.Цэдэнбалтай уулзаж Албаний Энвер Хожагийн дайрсан үгийн хувийг өгч, Хятадын хатгалгаар хийж байгаа ажил гэж тайлбарлаад, “Танайх Чойбалсанг тойруулан нэг их яриа гаргах хэрэг байна уу даа. Тэр хүн бол хоёр улсын найрамдалд үнэнч хүн байсан, тэр талаар их ажил хийсэн хүн. Хэрэв энэ талаар яриа гаргавал цаад талын этгээдүүд чинь ашиглаж магадгүй” гэжээ. Зөвлөлтийн удирдагчдын байр суурь Ю.Цэдэнбалын цаашдын ажиллагаанд саар нөлөө үзүүлснээс тэрээр Монгол дахь нэг хүнийг тахин шүтэх явдалтай тэмцэх бодлого ЗХУ-д хохиролтой явдал болох бий гэж эмээх хандлагыг хуваалцаж байв”²⁰ гэжээ.

1962 оны II сарын 17-ны МАХН-ын ТХ-ны УТТ-ны “Чойбалсангийн нэрэмжит газруудын тухай” 62 тоот тогтоолоор Чойбалсан сум, хот, гудамж, I арван жил, мото буудлагын хороог нэрэмжит хэвээр байлгах, Чойбалсан аймгийг Дорнод болгох, Чойбалсан сонинг “Улаан туг” болгох, бусад нэрэмжит газруудыг болиулах шийдвэр гаргасан юм.²¹ Өмнөх удирдагч Х.Чойбалсанг тахин шүтэж байсныг шүүмжлэх, засан залруулах ажил ерөнхийдөө аядуу байсан нь Ю.Цэдэнбалын хувийн байр суурьтай холбоотой байснаас гадна өөр шалтгаан байсан юм. Ю.Цэдэнбал, Н.С.Хрущев нар нэг хүнийг тахин шүтэх явдлын эсрэг тэмцэлдээ баримтлах бодлогоо зохицуулж байсан бөгөөд 1963 оны V бүгд хурал дээр Ю.Цэдэнбал хэлсэн үгэндээ энэ тухай ярьжээ. Үүнд: “Би Москвагаас наашаа буцахын өмнө нөхөр Хрущевтэй уулзсан, тэр үед аж ахуйн талаар тавьсан асуудлууд ч байсан юм. Нөхөр Хрущев элэгсэг дотно хүлээн авч зохих зөвлөгөө өгсөн, үүнд нэг хүнийг тахиж шүтэхтэй холбогдсон асуудалтай уялдуулж зөвлөгөө өгсөн. Тэгэхдээ манайд бас эрүүл бус байдал байгааг тэр нөхөд ч мэдсэн юм байна билээ. Нөхөр Хрущев юу гэж хэлснийг II бүгд хурлын өмнө аймгийн намын хороо, гүйцэтгэх захиргааны дарга нарт би ярьж байсан. Нөхөр Хрущев хэлэхдээ: “Танай тэнд чинь дайснаа цагаатгах хандлага байх шиг байна. Та нар хэлмэгдсэн хүмүүсээ цагаатгах гээд дайснаа цагаатгах хандлага руу орж

²⁰ Б.Лхамсүрэн. 16-р жаран мину. –УБ., 2003, т.30,31

²¹ МАХН-ын Төв архив.ф. 4, д. 26, х.н. 4, т. 122

магадгүй байна. Бид нэг хүнийг тахин шүтэх явдал, түүний хор уршигтай тэмцэхдээ нэг ч дайсныг цагаатгаагүй, нэг ч дайсныг цагаатгахгүй, зөвхөн хэлмэгдэж, буруу шийтгэгдсэн тийм хүмүүсийг л цагаатгаж байгаа юм. Нөхөр Чойбалсангийн хувьд гэвэл тэр үеийн онцлогийг харгалзах хэрэгтэй. Тэр үед Япон дэргэд чинь байсан уу? байсан, гоминдан байсан уу? байсан, дотоодын дайсан байсан уу? байсан. Тэгэхлээр дайснаа эцсийн эцэст цагаатгах гэж байна уу? энэ бол буруу хэрэг байгаа юм. Ийм байдалд хүргэж болохгүй” гэж зөвлөгөө өгсөн билээ²² гэж хэлжээ. ЗХУКН-ын зүгээс манай намд ер нь хэт хувьсгалчирхаг маяг хандлага гаргаж хэрэггүй гэсэн зөвлөлгөөнийг өгч байсан нь сонин бөгөөд нэг хүнийг тахин шүтэхийн эсрэг явуулах тэмцэлдээ Монголын удирдагчид энэ санааг мэдээж харгалзсан билээ.

Зарим хүмүүс Ю.Цэдэнбал нь тавь, жараад онд олон хүнийг ажлаас халж хохироож байснаас гадна гучаад оны асуудлыг авч хэлэлцэх болгонд хаацайлж, бараг л тэр үйл явдалд хүүхэд байхдаа оролцож байсан юм шиг тайлбарлаж, Х.Чойбалсанг хамгаалж байсан гэж үздэг юм. Ардын хувьсгалын анхны нэг удирдагч, Монгол Улсын тусгаар тогтнолын төлөө цогтой тэмцэгч Улсын Маршал, өөрийг нь дэмжиж дэвшүүлж, түшиж тулж байсны хувьд Х.Чойбалсантай бараг эцэг хүү шиг л хамтран ажиллаж, үг сургаалийг нь дагаж, хожим хөшөө бунхныг нь босгож, 10 гаруй нэрэмжит газар буй болгож байсан бөгөөд хожим нь ямар нэг хэмжээгээр хаацайлж байсан ажээ. Нарийн ярьвал хэлмэгдүүлэлтийн асуудалд хандах хандлагаа тодорхойлоход Ю.Цэдэнбалд өөр бодит хүчин зүйлүүд ч нөлөөлж байжээ. Арваадхан жилийн өмнө болсон, монголчууд нэгийгээ алж хядсан, бурангуй үйл явдлыг үр хүүхдүүдийнх нь дунд улс төржүүлэн сөхөж тавих, сэдрээх нь зохимжгүй гэж тэр үеийн удирдлага үзэж байсан юм.

Гучаад оны хэлмэгдүүлэлтийн асуудлыг Ю.Цэдэнбалын үед олон дахин нарийн судлуулж байсан, тусгай томоохон илтгэлийг ч дээд зиндаанд олон хэлэлцэж байжээ. Энэ нь алхам тутамдаа Монголын эрх баригчид төдийгүй Зөвлөлтийн КГБ, тэндэхийн төлөөлөгчдийн үйл ажиллагаатай холбоотой байсан нь нам, төрийн дээд удирдлагыг мухардалд оруулж байсан байна. Монгол Улсын тэр үеийн ганц өмөг түшиг, гол спонсор орны нэр төрийг сэвтүүлэх нь улс төрийн төдийгүй, эдийн засгийн хувьд ч манайд ашиггүй гэж үзэж, асуудлыг учиргүй улс төржүүлж, шуугиулж дэвэргэлгүй засах арга замаа хайх, хэрэгжүүлэх нь зөв гэж Ю.Цэдэнбал үзэж байлаа.

МАХН-ын ТХ-ны 1962 оны II бүгд хурлын өмнөхөн I сарын 15-нд УТТ-ны хурал болж “УАХГ-ын ажилд гарч байсан алдаа завхралыг шалгасан комиссын ажлын үр дүнгийн тухай” асуудал хэлэлцжээ. Тэр хурал дээр Ю.Цэдэнбал хэлмэгдүүлэлтийн талаар дүгнэж хэлэхдээ: “Өнөөдөр бид

²² Ю.Цэдэнбал. МАХН-ын ТХ-ны V бүгд хурал (1963) дээр хэлсэн үг. –УБ., 1963.

Зөвлөлтийн нөлөө байсан гэж шуугихгүй. Яг үнэнээр хэлэхэд нөлөө байсан ч гарцаагүй л дээ... Тэгэхдээ ганц түүнээс болсон гэж би үзэхгүй. Манай нөхдийн болхи муу ажиллагааны нөлөө ч байж болох юм л даа. Гол шалтгааныг Зөвлөлтийн нөлөө гэж үзэж болохгүй. Үүнийг ашиглах ямар нэгэн илрэл гарч болохоос болгоомжлох хэрэгтэй. Манай хоёр улсын найрамдал хэзээ ч бат бэх байна²³ гэжээ. Хэлмэгдүүлэлтээс хойш 50 гаруй жил өнгөрсөн, хүмүүсийн хэд хэдэн үе дамжсаны дараа ерээд онд асуудлыг нухацтай ярьж, түүхийн баримтыг тодорхой тавьж, хохирогчид болон үлдэгсдийн сэтгэлийг дэвтээх буяны ажил хийсэн нь тун зөв арга хэмжээ болсон юм.

Ю.Цэдэнбал гучаад оны үйл явдал, түүнтэй голлон холбогдох Х.Чойбалсангийн талаар баримталж байсан бодлогыг зарим хүн хатуудлаа гэж үздэг. Зарим нь зөөлдлөө. Ю.Цэдэнбал бол Х.Чойбалсангийн цуст үйлдлийг хаацайллаа, бараг л залгамжлаад олон хүнийг ажлаас халсан, хоёулаа дарангуйлагч байсан гэж бичдэг. Гуравдагч хэсэг нь: Ю.Цэдэнбал хатуу ч биш, зөөлөн ч биш, асуудалд бодитой, шинжлэх ухаанчаар хандсан, ингэж хандах нь зөв гэж үзэж ирсэн юм.

Маршал, Жанжин хоёрын хамтын ажиллагаа. XX зууны Монголын цэргийн гарамгай зүтгэлтэн Ж.Лхагвасүрэн бол Ю.Цэдэнбалын цэргийн талын дайчин нөхөр, түүний тулгуур нь байсан гэдэг нь ойлгомжтой билээ. Гэвч түүнийг Сайдын тушаалаас буулгасан, нэрт жанжинд Монгол Улсын Баатар цол олгох зүй ёсны ажил хийгдэлгүй байсаар Маршал Ю.Цэдэнбал ажлаас чөлөөлөгдсөний нууц тайлагдаагүй байна. Энэ хүнд Баатар цол өгөөгүй мөртлөө өөрөө Баатар болсон гэх ч яриа байдаг. Сонин хувь тавилантай Маршал, Жанжин хоёрын нийгэм, улс төр, цэргийн дээд зиндааны үйл ажиллагаа нэг зэрэг 1939 онд эхэлжээ. Энэ онд Ж.Лхагвасүрэн МАХЦ-ийн УТГ-ын орлогч ба дарга, Ю.Цэдэнбал СЯ-ны орлогч ба жинхэнэ сайд, 1940 онд Намын Х их хурлаас хоёул НТХ-ны Тэргүүлэгч гишүүн болж Ю.Цэдэнбал нь Ерөнхий нарийн бичгийн дарга болжээ. Удалгүй Ю.Цэдэнбал Армийн комиссар, Бүх цэргийн жанжны орлогч, Армийн УТГ-ын даргын ажлыг хавсран хийх болж, Ж.Лхагвасүрэн нь ЦЯЯ-ны орлогч сайд, Бүх цэргийн жанжны орлогч байж, хоёул 1945 оны дайнд оролцжээ. 1944 онд хоёулхнаа цэргийн дээд цол – дэслэгч генерал цол хүртжээ.

Монгол Улсын тусгаар тогтнол, хөгжил дэвшлийн төлөө гарамгай гавъяа байгуулсны төлөө 1939 онд Ж.Лхагвасүрэн Байлдааны гавъяаны Улаан тугийн одонгоор, Ю.Цэдэнбал 1941 онд Хөдөлмөрийн гавъяаны Улаан тугийн

²³ Л. Бат-Очир. Х. Чойбалсан: Намтрын нь балархайг арилгахуй. –УБ., 1996, т. 143

одонгоор шагнагджээ. “Германы фашизмын булаан эзлэгчидтэй тэмцэж байгаа Улаан цэрэгт эд хэрэглэгдэхүүний тусламж хүргэх явдлыг зохиоход гарамгай гавьяа байгуулсны төлөө Х.Чойбалсан, Ю.Цэдэнбал, Г.Бумцэнд нар СССР-ийн Лениний одонгоор 1944 онд шагнагджээ. “Японы эзэрхэг түрэмгийг эсэргүүцсэн дайнд МАХЦ-ийн байлдааныг гарамгай удирдаж, эрэлхэг баатарлагийг гаргасан учир” СССР-ийн Дээд зөвлөлийн Тэргүүлэгчдийн зарлигаар (1945 оны IX сар) Маршал Х.Чойбалсанг Суворовын I зэргийн одонгоор, дэслэгч генерал Ю.Цэдэнбалыг Кутузовын I зэргийн одонгоор, дэслэгч генерал Ж.Лхагвасүрэнг Суворовын II зэргийн одонгоор шагнажээ. “Нийтийн дайсан Японы империализмыг бүрмөсөн устгах шударга байлдаанд МАХЦ-ийг гарамгай удирдаж чадсан учир” 1945 оны IX сард дэслэгч генерал Ю.Цэдэнбал, дэслэгч генерал Ж.Лхагвасүрэн нарыг манай төр, засаг Байлдааны гавьяаны улаан тугийн одонгоор тус тус шагнажээ. Хожмын Маршал, Жанжин хоёрын дайн байлдааны үеийн үйл ажиллагаа, гавьяа алдрыг Холбоотон гүрнүүдийн нэг ЗХУ, мөн Монголын төр, засаг тухайн цаг үед нь ийнхүү өндөр үнэлж байжээ.

1952 онд Ю.Цэдэнбал Ерөнхий сайд болоод цэргийн асуудлыг хариуцаагийн хувьд нэрт жанжин Ж.Лхагвасүрэнг Цэргийн ерөнхий сургуулийн захирлаас татаж 1953 онд БХЯ-ны орлогч сайд болгожээ. Улмаар Ж. Лхагвасүрэн жанжин Батлан хамгаалах яамны сайд болж, 1969 он хүртэл нэр төртэй ажилласан билээ. Сайдаас чөлөөлөгдөх үед нь НТХ, СнЗ, мөн цэргийн хүрээнд түүнтэй өрсөлдөгчид нэлээн хүчтэй байсан нь Ж.Лхагвасүрэнд зарим талаар дарамт үзүүлж байсан ажээ. 1966 оноос дээд удирдлагадаа чөлөөлөгдөх өөрийн санал удаа дараа тавьж байсан байна. Ер нь БХЯ-ны сайдын ажлыг дээд түвшинд хэлэлцье гэдэг санал энэ үед олонтаа тавигдах болсон ч Ж.Лхагвасүрэнг шүүмжлэх, тэр тусмаа ажлаас нь өөрчлөх төдийлөн сонирхолгүй байсан Ю.Цэдэнбал хэд хэдэн удаа хойшлуулсан тухай түүний туслахын тэмдэглэлд бичигджээ.²⁴

1969 оны VII сарын 3-нд УТТ сайд Ж.Лхагвасүрэнгийн ажлын тухай хэлэлцжээ. Гишүүд ч цэргийн сахилга, аж байдлын талаар нилээн асууж, шүүмжлэл ч нилээн гарчээ. Ж.Лхагвасүрэн гуай хэлэхдээ: “Би уг нь чөлөөнд гаръя гэж даргад илтгэсэн дээ. Гурван жилийн өмнө ч байна уу даа. Одоо ч хождоогүй байна... Үнэндээ олон жил ч хийлээ. Одоо тэгээд зарим удирдах хүмүүс удирдаж байгаа хүнээр нь зэвсэгт хүчний ажлыг дүгнэх гээд байгаа тал харагдаад байна. Би тэгж армийг хохироож байж болохгүй. Тэгэхлээр үүнийг далимдуулаад надад чөлөө өгөөч. Би одоо УТТ-нд хүсч байна. Миний хувьд

²⁴ Нийслэлийн сонин бичиг, 1996.1.23. № 4

ийм байна”²⁵ гэжээ. Товчооны гишүүд ч олонхийн саналаар ажлаас нь чөлөөлөхөөр шийджээ. НТХ, СнЗ-ийн арми хариуцсан ажилтнууд, болон УТТ-ныхны саналыг дагалдах маягаар Ю.Цэдэнбал энэ асуудалд ханджээ. Хурал дээр ажил төрлийн зарчмын асуулт тавьдаг тэр л зангаараа Ю.Цэдэнбал асууж танилцаж байснаас биш муучлан чичилж, ажлаас нь чөлөөлнө гэж санал тавьж, зүтгэж байсан баримт факт байхгүй байна.

Ард түмний дунд өндөр нэр хүндтэй Жанжин Ж.Лхагвасүрэнг Ж.Самбуу, Ю.Цэдэнбал нар тун удалгүй БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн Ардын депутатуудын хурал, байнгын комиссын асуудал эрхэлсэн товчооны даргаар томилж, 1972 онд Ж.Самбуу гуай хүнд өвчтэй байх үед Ю.Цэдэнбалын саналаар Ж.Лхагвасүрэнг АИХ-ын Хурлын хэлтсийн даргаар томилж, энэ үеэс Жанжин Лхагвасүрэн төрийн талын хоёрдох хүн болж, Самбуу гуай өөд болсны дараа 1972-1974 онд АИХ-ын ажлын ачааны хүндийг үүрч Ю.Цэдэнбалтай гар нийлэн ажилласан юм. 1978 онд өөрийнх нь хүсэлтээр, Ю.Цэдэнбалын зарлигаар БНБАУ-д Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар томилж, 1980 онд нутагтаа ирэхэд нь Ю.Цэдэнбал Ж.Лхагвасүрэнг АИХ-ын Тэргүүлэгчдийн хурлын Хэлтсийн зөвлөх гэдэг шинэ орон тоо гарган ажиллуулж байсан юм.

Ю.Цэдэнбал, Ж.Лхагвасүрэн нарын удирдлагын дор дайнд оролцсон зарим дээд дарга нар Улсын Баатар болцгоов. Энэ талаар Ю.Цэдэнбал дарга ч анхаарал тавих болов. Энэ үеийн талаар Жанжины охин Л.Лхагвадулам дурсахдаа: “Цэдэнбал даргыг аав хүндэлдэг байсан. Харин Цэ дарга хүний үгэнд их автамтгай гэж сонссон. Тэр нь л их нөлөөлсөн байх гэж боддог. 1979 онд Болгарт Элчин байхад нь аавыг Ю.Цэдэнбал дарга Москвагаас дуудаад Халх голын ойн үеэр Монголдоо байх хэрэгтэй гээд өөрийнхөө онгоцоор авчирсан. Ойн урьд өдөр аавыг Баатар болгох тухай аавын нэртэй Зарлигийн төсөл явж байгаад маргааш нь өөр хүний нэртэй гарсан”²⁶ гэжээ. Бараг л бүхнийг ганцаараа шийддэг гэгддэг Ю.Цэдэнбалд ямар хүч нөлөөлсөн нь тодорхойгүй, санасандаа хүрэлгүй өнгөрчээ. Ю.Цэдэнбалын нэр төрийг нь бууруулах, алдар хүндтэй, итгэлтэй, эртний найз нөхдөөс нь хол байлгах, улс төрийн хүрээнд түүнийг улам ганцаардуулах сөрөг хүчний холын бодлого нөлөөлсөн байж магадгүй. Ийм байдлаар Ю.Цэдэнбалын итгэлтэй дотнын нөхөд Ч.Пүрэвжав, С.Жалан-Аажав, С.Удвал, Б.Ширэндэв нарыг удаа дараалан өөрчилсөн билээ. Монголын цэргийн нэрт зүтгэлтэн, өөрийн дайчин анд Ж.Лхагвасүрэнг энэ үед зүтгэж байгаад Улсын Баатар болгоогүй нь үнэхээр түүний алдаа болсон бөгөөд олон түмний гайхлыг төрүүлсээр ирсэн

²⁵ Бодрол, бясалгал, 1991, № 9, т. 46

²⁶ Үнэн, 1999.3.17, № 30

билээ. Нөгөө л хүний ая дагадаг, бусдын санал харгалздаг зан нь нөлөөлсөн бололтой байдаг. Маршал Ю.Цэдэнбал, жанжин Ж.Лхагвасүрэн нарын жирийн харилцааны талаар хурандаа генерал С.Лувсангомбо дурсахдаа: “Цэдэнбал, Лхагвасүрэн хоёр муу байсан гэж хэлэх л юм байгаагүй. Лхагвасүрэн гуай жаахан хурц хүн л дээ. “Тэгвэл би энэ сайдыг чинь хийж чадахгүй” гэх жишээтэй. Гэвч тэд олон жил хамт зүтгэсэн”²⁷ гэжээ.

Жанжин Ж.Лхагвасүрэн дотно дайчин андын хувьд Маршал Ю.Цэдэнбалд Зөвлөлтийн цэргийн академид сурдаг хүүтээ биечлэн танилцуулж байжээ. Эрдэм боловсрол төгс хүүг нь нам, засаг 1974 онд Иргэний агаарын тээврийг удирдах ерөнхий газар (ИАТУЕГ)-ын Ерөнхий инженер болгожээ. 1980 онд Ю.Цэдэнбал ажил сайжруулах талаар залуу инженерийн гаргасан саналтай зориуд биечлэн танилцаад, өндөр үнэлэн дэмжиж ИАТУЕГ-ын даргаар томилжээ. Удалгүй залуу даргын хүсэлтийг үндэслэн ЗХУ-д туршлага судлуулахаар Ю.Цэдэнбал өөрийн биеэр уулзан үүрэг өгч явуулж байжээ. 1982 оны V сард Жанжин Лхагвасүрэн насан өөд болж нутаглуулсны дараа Ю.Цэдэнбал хүүг нь тусгайлан хүлээн авч: “Аавын чинь оршуулгын газрыг тохижуулах зардлыг улс даана” гээд хөшөө дурсгалыг нь яаж босгох талаар эцэг ёсны зөвлөмж өгч байжээ.

1982 онд Намын хянан шалгах хороо нисэхийн ажилд шалгалт хийж “Л.Лхагва шаардлага хангахгүй байна, өөрчлөх нь зүйтэй” гэсэн санал тавьсан боловч Ю.Цэдэнбал Л.Лхагвын ажлыг өөрчлөх биш, харин итгэж цаашид ажиллуулах, ажил сайжруулах үүрэг тавьжээ. Жанжины хүү ч Маршалын итгэлийг биелүүлж ажлаа сайжруулж чаджээ.²⁸ Жанжин Ж.Лхагвасүрэнгийн хүү, хурандаа Л.Лхагва дурсахдаа: “Тэгэхэд аав намайг дуудаж оруулаад “Энэ миний хүү, Зөвлөлтийн цэргийн академид сурдаг” гэж хэлээд намайг Цэдэнбал даргад танилцуулж байсан нь миний даргатай анх удаагийн уулзалт болсон юм. Цэдэнбал дарга их элэгсэг дотноор чиний хүү чинь том эр болжээ. Хүмүүжилтэй, сайн хүү. Сайн хүн болноо. Ажил, амьдрал бүхэн өмнө чинь хүлээж байна даа, хичээх хэрэгтэй гэж билээ. Дарга, аав хоёр үнэхээр бие биедээ түшиг болсон цэргийн дарга нар байсан нь тэдний яриа, нөхөрлөлөөс харагддаг байсан юм. Одоо тэдний хэн хэн нь байхгүй, тэдний үерхэл, нөхөрлөл, амьдрал, тэмцэл түүх болон үлджээ”²⁹ гэж Маршал, Жанжин хоёрын сайхан харилцааг гэрчлэн бичжээ.

Ж.Лхагвасүрэнгийн дурьдатгал ном дээр ажилласан сэтгүүлч Да.Дамдиндорж дурссанаар жанжны 70 насны ойн үеэр Цэдэнбал дарга уулзахдаа “Чи ер нь бүрэн хэмжээний дурьдатгалын номоо бич. Би Армийн

²⁷ Ю.Цэдэнбалын Академийн архив. ф.1, хн.5, т.17

²⁸ Л.Лхагвагын дурсамж. Зохиогчийн хувийн архив.

²⁹ Ю.Цэдэнбал, Монгол орон. –УБ.,2003,т.222

улс төрийн газрын даргад үүрэг өгч, хүн гаргуулж туслуулъя” гэж хэлсэн. Тэгээд л генерал Д.Ёндондүйчэр гуай намайг томилж, Лхагвасүрэн Жанжины дурьдатгал бичих үүрэг өгсөн³⁰ гэжээ.” Их Жанжины алдар гавъяаны түүхийг залуу хойч үедээ уламжлан мэдүүлэх гэсэн Ю.Цэдэнбалын бодол нь ийм санаачлага гаргахад хүргэсэн бөгөөд түүний дэмжлэгээр Ж. Лхагвасүрэн гуайн дурсамж ном хэвлэгдсэн ажээ. Дайчин анд нөхрийнхээ номонд их анхаарч байсан нам, төрийн тэргүүн цаг зав гарган энэ номын эхийг нь уншиж, бодол санаа, зөвлөгөө Жанжинд өгч байжээ.”³¹ Х.Чойбалсан, Ю.Цэдэнбал, Ж.Лхагвасүрэн нар нь Монголын тусгаар тогтнолын төлөө үйлсэд үнэнч зүтгэсэн цэргийн зүтгэлтнүүд байв. Тэд нэгнийгээ учиргүй хамгаалдаг, санаа бодол бүх талаар нийлдэг дотны шадар найз нар ч байгаагүй бололтой. Тэр хоорондоо аль нэгэн асуудлаар зөрчил маргаантай, сөргөлдөөнтэй байсан гэх ноцтой баримт ч олдохгүй байна. Тэдний харилцаа нь ажил төрлийн эрх ашиг, нэгнийгээ хүндэтгэх хүнлэг ёсны зарчим дээр тулгуурласан цэрэг эрсийн жинхэнэ дайчин нөхөрлөл байжээ.

Abstract: The friendship and partnership between Kh.Choibalsan, Yu.Tsedenbal and J.Lkhagavasuren based on the national interests and was a human-based relationship, rised during the war-time.

³⁰ Ю.Цэдэнбалын Академийн архив. ф1.хн.12.т.232

³¹ Мөн тэнд